



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар A/152

Мандалговь

Г

Т

Ажлын хэсэг байгуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А/145 дугаар тушаалаар баталсан "Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам"-ын 3.3 дахь хэсэг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны А/108 дугаар тушаал, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын байгуулсан үр дүнгийн гэрээний 67 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан суманд үржүүлж буй "Нутгийн шилмэл" мах ноосны чиглэлийн хонинд явуулсан үржил селекцийн ололтыг хянан магадлах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох орон нутгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

|                       |  |
|-----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Р.Мөнхтогтох (Сайнцагаан сумын Засаг дарга)  |
| Нарийн бичиг:         | Т.Батсайхан (Хөдөө аж ахуйн төсгийн мэргэжилтэн)   |
| Гишүүд:               | Б.Өлзийбаяр (Сумын ИТХ-ын дарга)<br>Б.Оюунчимэг (Тамгын газрын дарга)<br>Ж.Батбилэг (ХХААГ-ын мал үржлийн албаны даргыг түр орлон гүйцэтгэгч)<br>Ж.Бурмаа (Нягтлан бодогч)<br>Е.Отгонцэцэг (Мал эмнэлгийн тасгийн дарга)<br>С.Хорлоо (Цөм сүргийн үржлийн төвийн менежер)<br>Н.Баярсайхан (Наран багийн Засаг дарга)<br>Ш.Батбаатар (Тэвш багийн засаг дарга)<br>Ж.Зоригтбаатар (Далай багийн засаг дарга)<br>Т.Батжаргал (Үйзэн багийн засаг дарга) |

Хоёр. Үржил селекцийн ажлын ажлын үр дунд хянан магадлагаа хийх ажлыг холбогдох хууль, журамд нийцуулэн зохион байгуулж, ажлын тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Мөнхтогтох)-д үүрэг болгосугай.

Гурав. Хянан магадлагаа хийхэд шаардагдах зардлыг малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх хэсэгт заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488190421